

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠤᠳᠢᠲᠢ ᠶᠡᠨ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮН БАГАТАЙ,
ОРОН НУТАГТ АЖЛЫН БАЙР БОДИТООР НЭМЭГДЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД:
АРА-2022/20-1-ШТА-ГА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, ахлах аудитор Х.Алтанчимэг
Утас: 9006-0105 Цахим хаяг: altanchimegkh@audit.gov.mn
Аудитор Н.Энхчимэг
Утас: 8989-1150 Цахим хаяг: enkhchimegn@audit.gov.mn
Аудитор Б.Анхтуяа
Утас: 9941-2231 Цахим хаяг: ankhtuyabo@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2022 ОН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3-4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ	5-6
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	6-9
АУДИТЫН ТАЙЛАН.....	10-37

БҮЛЭГ 1: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН БАГАТАЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

- 1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой бүрэн уялдаагүй байна.
- 1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж чадаагүй байна.
- 1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар дундын төрийн бодлогын уялдаа холбоо бүрэн хангагдаж чадахгүй байна.

БҮЛЭГ 2: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГ БАГАТАЙ БАЙНА.

- 2.1. Хөдөлмөр эрхлэлтийн ниитлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөө багатай байна.
- 2.2. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна.
- 2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй ч хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна.
- 2.4. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөө бага байна.
- 2.5. “Ковид-19” цар тахлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	38
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	39
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	40-44
ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ.....	45-46
УЛАМЖЛАХ САНАЛ.....	47-48
ХАВСРАЛТ СУДАЛГАА.....	48-49
АЛБАН ШААРДЛАГА.....	50-хойш

Товчилсон үгийн тайлбар:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МБС	Мэргэжлийн боловсролын сургалт
МБСДС	Мэргэжлийн боловсролын сургалтыг дэмжих сан
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НЭЗХ	Нийгэм, эдийн засгийн хөгжүүлэх
ШТА	Шууд тайлагналын ажил
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
УИХ	Улсын их хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААГ	Хүнс, хөдөө, аж, ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар
ХЗЗЭН	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
СХС	Сум хөгжүүлэх сан
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Алату үүлдрийн үхэр /ЖДҮХС/	25
Зураг 2	Үйлдвэрийн барилга /ЖДҮХС/	26
Зураг 3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /ЖДҮХС/	26
Зураг 4	Цахир суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд	31
Зураг 5	Эрдэнэмандал суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд/	31
Зураг 6	Ихтамир суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд	32

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Дугаар
График 3	Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, /хэмжих нэгж: мян.хүн/	12
График 3	Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт /хэмжих нэгж: хувь/	13
График 3	2016-2021 онуудад аймгийн хэмжээнд бий болсон ажлын байр	13

Хүснэгтийн товч

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ажлын байр нэмэгдсэн байдал	7
Хүснэгт 2	2016-2021 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	8
Хүснэгт 3	2016-2021 онд ХЭДС-аас орон нутагт хуваарилсан санхүүжилт	8
Хүснэгт 4	Аймгийн хэмжээний МСҮТ-ийн 2016-2021 оны суралцагчдын тоо, санхүүжилтийн мэдээ	8
Хүснэгт 5	2016-2021 оны бодлогын баримт бичгийн уялдаа	9
Хүснэгт-6	ХЭДС-аас орон нутагт хуваарилсан санхүүжилт	16
Хүснэгт 7	ХЭСЗ-ийн үйл ажиллагаа	18
Хүснэгт 8	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ /2016-2021 он/	20
Хүснэгт 9	ЖДҮХС-ийн хөрөнгө, ажлын байр нэмэгдсэн байдал /сая.төг, хүн/	23
Хүснэгт 10	СХС-аас 2016-2021 онуудад олгосон зээлийн байдал	24
Хүснэгт 11	Сум хөгжүүлэх сангаас олгосон санхүүжилт /хэмжих нэгж: сая.төг, хүн/	24
Хүснэгт 12	2026-2021 онуудад эргэн төлөгдөх санхүүжилт олгосон байдал / хэмжих нэгж: сая.төг/	28
Хүснэгт 13	2026-2021 онуудад ХБИ орлого төвлөрсөн байдал/	29
Хүснэгт 14	2016-2021 онуудад ХЭДС-ын төсөл хөтөлбөрийн зарцуулалт /хэмжих нэгж:сая.төг, хүн/	29
Хүснэгт 15	МСҮТ-ийн санхүүжилт, хүүхдийн тоо / хэмжих нэгж:сая.төг, хүн/	33
Хүснэгт 16	МСҮТ-ийн төгсөгчид, ажлын байр	34
Хүснэгт 17	Ажлын байр дэмжих зээл авсан байдал /хэмжих нэгж: сая.төг, хүн/	35
Хүснэгт 18	Цар тахлын үеийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээ /хэмжих нэгж: хүн, хувиар/	36

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР:

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн”

АУДИТЫН КОД:

АРА-2022/20-1/ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх;
2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх.

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол улсын ЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т тусгасан төсөл, хөтөлбөр зорилго арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн Аймгийн засаг даргын тамгын газар, ХХҮГ, НДХ, ХХААГ, аймагт үйл ажиллагаа явуулдаг МСҮТ болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч иргэн ААНБ-уудын 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулсан судалгааны ажлыг боловсруулж, ХЭДС, СХС-ийн 2020, 2021 оны анхан шатны баримтыг шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 тоот тушаал “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 тоот тушаал “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг



цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Ахлах аудитор Х.Алтанчимэг, аудитор Н.Энхчимэг нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2022 оны 03 сарын14-нөөс эхлэн гүйцэтгэж 2022 оны 05 сарын 02-нд Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, засаг дарга, шалгагдагч байгууллагууд болон ҮАГ-т хүргүүлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Төрийн аудитын байгууллагаас аудитын хамрах хугацаанд ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад 2 удаа /2015-2016 он, 2018-2019 он/, ЖДҮ-г хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад 2 удаа /2016-2017 он, 2019-2020 он/-д гүйцэтгэлийн аудит хийгдсэн тул тус аудитын дүн дүгнэлтийг үндэслэсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Монгол Улс нь “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенц”-ийг 2015 онд, “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88 дугаар конвенц”-ийг 2016 онд соёрхон баталсан байна. Монгол улсын хөдөлмөрийн харилцаанд эдгээр конвенцод заасан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх үндэсний сүлжээг бүрдүүлж хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үүргийг хүлээжээ.

Монгол улсын ЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын ерөнхий хүрээ болсон юм.

Энэхүү баримт бичиг нь 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтуудтай уялдсан байх шаардлагатай юм.

Бодлогын нэгдүгээр үе шат нь 2016-2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг МУЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

Архангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлтийг 100% гэж дүгнэжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд 2016-2021 онд Архангай аймагт нийт **6019** ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 1: Ажлын байр нэмэгдсэн байдал

Үзүүлэлт*		2016	2017	2018	2019	2020	2021	НИЙТ
1	ХАА	112	383	234	329	174	146	1378
2	Боловсруулах үйлдвэрт	260	271	20	35	95	43	724
3	Барилга	112	16	88	144			360
4	Боловсрол		92	103	82	86	65	428
5	Бөөний болон жижиглэн худалдаа		170	15	11	18	37	251
6	Бусад	290	467	552	369	530	670	2878
Нийт		774	1399	1012	970	903	961	6019

*ХХҮГ-аас ирүүлсэн тайлангаас

Хүснэгтээс харахад 2017-2018 онуудад ажлын байр нэмэгдсэн ч 2019-2021 онуудад буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь 2016-2021 онуудад ХЭҮЗ-өөс баталсан дараах төсөл хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 2: 2016-2021 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр

2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд		2017-2020 онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд		2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ		Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ		Ажилд зуучлах үйлчилгээ	
3	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр		Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр				
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр		Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	
8	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр		Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл		Хүүхэд хамгаалагч төсөл	
10	Жижиг зээл	Жижиг зээл		Жижиг зээл	

ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2016-2021 онуудад нийт **5,998.2** сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр **5,108.8** сая төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 3: 2016-2021 онд ХЭДС-аас орон нутагт хуваарилсан санхүүжилт

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2016	1066.4	449	617.4
2017	1035.5	966.1	69.4
2018	1283.8	1178.3	105.5
2019	1297.1	1233.2	63.9
2020	640.9	625.5	15.4
2021	674.5	656.7	17.8
Нийт	5998.2	5108.8	889.4

*Эх сурвалж: Санхүүгийн тайлан

Хүснэгтээс харахад 2020-2021 онуудад ХЭДС-ийн санхүүжилт буурсан нь ковид-19 цар тахлын үед зарим төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Архангай аймгийн хэмжээнд 3 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жилд дунджаар 400-аад мэргэжилтэй ажилтан бэлтгэж байна. МСҮТ-ийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4: Аймгийн хэмжээний МСҮТ-ийн 2016-2021 оны суралцагчдын тоо, санхүүжилтийн мэдээ

№	Хичээлийн жил	Архангай МСҮТ		Гурван тамир МСҮТ		Булган МСҮТ		Нийт	
		Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт
1	2016-2017	472	906.2	160	96.7	300	296.6	932	1299.5
2	2017-2018	460	929.5	255	154.5	277	266.7	992	1350.7
3	2018-2019	472	955.6	370	224.5	405	377.7	1247	1557.8
4	2019-2020	509	1202.8	394	238.7	438	312.7	1341	1754.2
5	2020-2021	562	1495.8	310	188	412	265.2	1284	1949
НИЙТ ДҮН		2475	5489.9	1489	902.4	1832	1518.9	5796	7911.2

Хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилд МСҮТ-д **5976** суралцагчид сурч төгсөн **7,911.2** сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг болон тэтгэлэг авчээ. Энэ хэмжээгээр мэргэжилтэй ажиллах боловсон хүчин нэмэгдэж байгаа бөгөөд нийт төгсөгчдийн 60 орчим хувь нь ажлын байртай болсон мэдээлэлтэй байна. (МСҮТ-ийн ирүүлсэн судалгаанаас)

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын гамшгийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийг сэргээх, зах зээлийн идэвхжилийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх дунд хугацааны 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Энэхүү цогц төлөвлөгөөнд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг иргэнд 50.0 сая хүртэл, НӨАТ төлөгч аж ахуйн нэгжид 500 сая хүртэл төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатайгаар олгож эхлээд байна.

Цар тахлын үед ажлын байрыг хадгалах зорилгоор ЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Архангай аймагт **400** ААНБ-д 2020 онд **1,736.7** сая төгрөг, 2021 онд **341.8** сая төгрөгийн нийт **2,078.5** сая төгрөгийн НДШ-ийн хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлж, ажилгүйдлийн даатгалын сангаас 41 ААНБ-д **76.8** сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна. ХЭДС-аас "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч **60** иргэний төслийн материалыг хүлээн авч, **19** сумын өрхийн үйлдвэрлэл эрхлэгч **40** иргэнд **150.0** сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгож, 40 иргэн ажлын байртай болсон мэдээтэй байна.



Мөн хөдөлмөр эрхлэлтийн LMIS программд санхүүжилтийн эх үүсвэрээс нь шалтгаалан ажлын байрны бүртгэл мэдээллийг оруулж байгаа бөгөөд 2021 оны байдлаар улс орон нутгийн төсөв, гадаад дотоод хөрөнгийн эх үүсвэрээс **1150** ажлын байр шинээр нэмэгдэж, **1179** ажилгүйчүүдийг бүртгэсэн мэдээлэлтэй байна. /эх сурвалж: 2021 оны статистик мэдээ/

Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Хэрэглэгчээс-үйлдвэрлэгч аймаг болох зорилтын хүрээнд аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 29-ны 51 дүгээр тогтоолоор "Өрх бүр үйлдвэрлэгч" аймгийн дэд хөтөлбөрийг 2 үе шаттай явуулахаар баталсан байна. Тус дэд хөтөлбөр нь "Өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэнийг тодорхойлж, ажилгүй иргэдэд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлж, хувиараа болон жижиг дунд бизнес эрхлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж, хөрөнгө оруулалт бүрийг ажлын байртай уялдуулах замаар шинэ ажлын байруудыг бий болгох, ядуурлыг бууруулах, өрх бүрийг үйлдвэрлэгч болон хөгжих нөхцөлийг бүрдүүлэх" зорилготой боловсруулагдсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН БАГАТАЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ДУНД ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТТОЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА.



1.1.1. Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго, зорилтууд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар баталсан "Тогтвортой хөгжлийн зорилго-2030"-тай уялдсан эсэхийг орон нутгийн түвшинд шалгах боломжгүй юм.



1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байна.

Орон нутагт урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн уялдааг бүрэн шалгах боломжгүй байна. Урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 1-ээр харуулав./

Харин аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Аймгийн засаг дарга ХНХС-тай байгуулсан гэрээ зэрэг нь засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдсан бол нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, ХНХС, ХХҮГ-тай байгуулсан гэрээнүүд бүрэн уялдаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5: 2016-2021 оны бодлогын баримт бичгийн уялдаа

№	Бодлогын баримт бичиг	Он	Арга хэмжээ	Холбогдох бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх
1	Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	2016-2020	21	Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдсан.
2		2020-2024	14	
4	Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл	2017	4	ХНХС, ХХҮГ-тай байгуулсан гэрээнүүдтэй уялдаагүй.
5		2018	4	
6		2019	5	
7		2020	5	
9	Аймгийн засаг дарга ХНХС-тай байгуулсан гэрээ	2017	7	ЗГ-ын мөрийн хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдсан ч тоо болон чанарын үзүүлэлтээр хүрэх түвшинг хэрхэн тооцсон нь тодорхой бус.
10		2018	7	
11		2019	7	
12		2020	7	
13		2021	7	
9	Аймгийн засаг дарга ХХҮГ-ын даргатай байгуулсан гэрээ	2017	12	
10		2018	14	
11		2019	12	
12		2020	7	
13		2021	7	

Хүснэгтээс харахад аймгийн ИТХ-аар тайлант жилийн эцэст буюу 12 сард “Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батладаг бөгөөд энэхүү үндсэн чиглэлд

аймгийн Засаг даргын ХНХС болон ХХҮГ-тай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан арга хэмжээнүүд тусгагдаагүй, бүрэн уялдаагүй байна.

Аймгийн засаг даргын ХНХС болон ХХҮГ-тай жил бүр хамтран ажиллах гэрээнд орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ орон нутгийн онцлог, хэрэгцээ, өмнө нь хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэхгүйгээр боловсруулж байгаа нь учир дутагдалтай байна.

Тус гэрээнд хүрэх үр дүн үзүүлэлтийг бодитой тооцдоггүй, суурь үзүүлэлтийг баталдаггүй, өмнөх оны хэрэгжилтийн зөвхөн тоон үзүүлэлтийг харж, чанарын үзүүлэлтийг тооцоогүй нь богино болон дунд хугацааны баримт бичгийн уялдаа хангалтгүй байна гэж үзэхэд хүргэлээ



1.1.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судалгаанд үндэслэн бүрэн тооцоолохгүй байна.

А. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны талаар: Ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг жил бүр хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт хийдэг ба үүнд улсын хэмжээний мэдээлэл гардаг байна. Харин орон нутагт тус судалгааг тусгайлан хийдэггүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтүүдийг ҮСХ-ны дарга, ХНХ-ийн сайдын 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А-09/А-08 тоот тушаалаар батлагдсан аргачлалаар тооцдог аж.

Аймгийн засаг даргын 2019 оны 03 сарын 19-ны А/112 тоот захирамжаар хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулсан.

2019 онд хэрэгжүүлсэн суурь судалгаа нь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, их дээд сургуулийн элсэлт, төгсөлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгад нийцүүлэхээр ХХҮГ, Архангай МСҮТ, Статистикийн хэлтэс, сумдын засаг дарга нар хамтран зохион байгуулж үндсэн 7 чиглэлээр 18 сумын 187 ажил олгогч, 419 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 650 залуучууд, 1208 малчид, 1177 ажилгүй иргэд 1089 ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, 1425 их дээд сургууль болон МСҮТ-ийг төгссөн хүмүүсийг хамруулсан байна. Судалгааны үр дүнд:

- ❖ Аймгийн засаг даргын тамгын газарт ХЗЗЭН-ийн судалгааг 3 жил тутам авч байх, судалгааны үр дүнд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинээр бий болсон ажлын байрны хэрэгцээ судалгаанд үндэслэж ХХЭ, ААН-г бодлогоор дэмжих, ХЭСЗ-ийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зэрэг 4 заалт бүхий зөвлөмж,
- ❖ ХХҮГ-т ХЗЗЭН-ийн үйл ажиллагаатай холбоотой 12 заалт бүхий зөвлөмж,
- ❖ БСУГ, НТБТ-д их дээд сургууль төгсөгчдийн судалгааг жил бүр гаргаж, илүүдэлтэй мэргэжилд элсэлт авахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж тус тус хүргүүлжээ.

Судалгаанд аймгийн хэмжээнд 2020-2022 онуудад эрэлттэй болон илүүдэлтэй ажил мэргэжлийн талаар тусгасан ч хамрах хүрээ багатай мэдээлэл боловсруулалт дутуу байна. Учир нь зах зээлд эрэлт ихтэй, илүүдэлтэй ажил мэргэжлийн жагсаалтад зөвхөн Архангай МСҮТ-үүдийн ангийг хамруулсан нь учир дутагдалтай юм.

Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн бодит байдлыг харахад судалгааны үр дүнд өгсөн зөвлөмжүүдийг холбогдох байгууллагууд бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.

Аймгийн ХХҮГ-аас 2021 онд “Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөрийг боловсруулахаар **6606** өрхийн **17281** иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийн 2 дахь судалгааг боловсруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан иргэдийн 46.3% буюу **8014** иргэн хөдөлмөр эрхлээгүй байна.

Ажил эрхлээгүй шалтгааныг тодруулахад тухайн амьдарч байгаа газар өөрт тохирсон ажлын байр хомс, мэргэжил боловсролгүй, ар гэрийн шалтгаанаар өвчтэй хүн асардаг буюу хүүхдээ хардаг, мэргэжилд тохирох ажил олдохгүй, 40-с дээш настай тул ажилд авдаггүй, ажил олгогчийн тавьсан санал өндөр байдаг гэсэн дүгнэлтүүдийг хийж хувиараа хөдөлмөр эрхлэхэд хөнгөлөлттэй зээл тусламж, санхүүгийн болон тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах үйл ажиллагааг орон нутагт идэвхижүүлэх хэрэгтэй байгааг онцолжээ.


Тус дэд хөтөлбөр ИТХ-аар батлагдаагүй ч хөтөлбөрийн хүрээнд авсан судалгаа нь зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаас боловсруулсан нь нөгөө талаас нийлүүлэлт буюу ажил олгогчоос олгох ажлын байрны захиалгыг судалгаанд хамруулаагүй нь учир дутагдалтай байна.

Иймд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн мэргэжилтэй ажилтныг ажлын байраар хангах, ажил олгогчийг дэмжих бодит арга хэмжээ авч, хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжиж үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг Аймгийн засаг дарга, ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлээ.

Б. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар: 2021 оны байдлаар Архангай аймагт **95867** хүн амьдарч байгаа бөгөөд хөдөлмөрийн насны **62048** хүн байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам **42584** бөгөөд үүнээс **41252** мянган хүн ажиллагсад, **1179** бүртгэлтэй ажилгүйчүүд байна. 2016 онтой харьцуулбал: өрхийн хүн амын тоо **1700** буюу 6.3 хувиар, малчин өрхийн тоо **7762** буюу 53.7 хувиар, хүн амын тоо **2358** буюу 2.5 хувиар, хөдөлмөрийн насны хүн ам **6153** буюу 11.1 хувиар тус тус өссөн ч эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчин **2045** буюу 4.6 хувиар, ажиллагсад **1163** буюу 2.7 хувиар буурч бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо **1035** буюу 46.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2020, 2021 онуудад ковид-19 цар тахал гарч бүртгэлтэй ажилгүйчүүд буурсантай холбоотой байна.

Архангай аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг ҮСХ-оос гаргасан үзүүлэлтээр харуулбал:


График-1: Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, /хэмжих нэгж: төг.хүн/



Эх сурвалж: Архангай аймгийн Статистик хэлтэс

Графикаас харахад хөдөлмөрийн насны хүн ам 2019 оноос буурсан байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам 2020 оноос нэмэгдсэнээр ажиллагсдын тоо мөн адил нэмэгдэж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурсан байна.


График-2 : Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт /хэмжих нэгж: хувь/



Эх сурвалж: Архангай аймгийн Статистик хэлтэс

Ажиллах хүчний оролцооны түвшин 74.0-өөс 70.3, ажил эрхлэлтийн түвшин 72.2-оос 68.1 болж буурснаас шалтгаалан 2016 онд 5.0 байсан ажилгүйдлийн түвшин 2021 оны 4-р улирлын байдлаар 3.1¹ болтлоо буурсан байна. Гэтэл эдийн засгийн идэвхтэй хүн ам буурснаар ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо нэмэгдсэн байна. Ажилгүйдлийн үзүүлэлт нь зөвхөн эдийн засгийн идэвхтэй хүн амд ажиллагсдын эзлэх хувиар, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоогоор илэрхийлэгдэж байгаа нь ажилгүйдлийн түвшин буурах үзүүлэлт болж байна.

График- 3: 2016-2021 онуудад аймгийн хэмжээнд бий болсон ажлын байр



Эх сурвалж: Архангай ХХҮГ

Графикаас харахад манай аймагт ХАА, боловсруулах, барилгын чиглэлээр ажлын байр тогтмол бий болж байгааг харж болохоор байна. 2020-2021 онуудад ажлын байр өмнөх онуудаас буурсан нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Хэдий хөдөлмөрийн зах зээлийн судалгаа аймгийн хэмжээнд нэгтгэгдэж байгаа ч засаг даргын мөрийн хөтөлбөр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх бодит тооцоо судалгаа хангалтгүй байна.

Иймд ажлын байрны хэрэгцээ шаардлагын судалгааг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай уялдуулан хийж, орон нутгийн онцлогт тохирсон ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг Засаг дарга болон ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж байна.

Судалгааны талаар: Архангай аймгийн ажил эрхлээгүй иргэдээс авсан судалгаанд 18-60 насны нийт 50 иргэн хамрагдсан бөгөөд хүйсийн байдлаар эрэгтэй 26, эмэгтэй 24 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 52 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан, 48 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагүй ба хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн 21.6 хувь нь төрийн байгууллагад, 17.8 хувь нь ХАА-н салбарт, 17.8 хувь нь аж үйлдвэр, уул уурхайн салбарт, 25 хувь нь үйлчилгээний салбарт, 17.8 хувь нь бусад салбарт ажиллаж байсан. Иргэдийн дийлэнх нь 1-3 жилийн хугацаанд ажилгүй байжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн сарын орлогын эх үүсвэр нь хүүхдийн мөнгө 32 хувийг, гэр бүлийн гишүүдийн орлого 38 хувийг, бусад орлого 24 хувийг, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 2 хувийг, халамж 4 хувийг, мөн хөдөлмөр эрхлээгүй шалтгаан нь эрүүл мэндийн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн буюу 2 хувийг, ар гэрийн байдлаар 3 иргэн буюу 6 хувийг, боловсрол эзэмшиж байгаа 3 иргэн буюу 6 хувийг, КОВИД-19 цар тахлын улмаас ажлын байргүй болсон 2 иргэн буюу 4 хувийг, ажилд орохоор хүлээж байгаа 1 иргэн буюу 2 хувийг, тохирох ажил олдохгүй байгаа 4 иргэн буюу 8 хувийг, эзэмшсэн боловсрол ажилд нийцэхгүй байх 2 иргэн буюу 2 хувийг, ажлын байрны ажиллах нөхцөл муу 1 иргэн буюу 2 хувийг, цалин бага 18 иргэн буюу 36 хувийг, хүйсийн ялгаа заасан байдаг 1 иргэн буюу 2 хувийг, төрийн албаны шалгалтад хамрагдаагүй 1 иргэн буюу 2 хувийг, бусад шалтгаанаар 13 иргэн буюу 26 хувийг тус тус эзэлж байгаа зэргээс дүгнэхэд хөдөлмөрлөх насны иргэд ажил хийх идэвхи сонирхолгүй, иргэдийн хөдөлмөр эрхлэхэд цалин бага болон бусад шалтгаанууд нөлөөлж байгаа байдал ажиглагдаж байна. /Хавсралтаар судалгааны дүнг дэлгэрэнгүй оруулав./



1.1.4. Бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талын оролцоог хангаж ажиллаагүй байна.

А. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын талаар: Орон нутагт төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр боловсруулан ажиллаагүй тул төрийн болон мэргэжлийн холбоодыг хамруулсан эсэхийг шалгах боломжгүй юм.

Б. "Өрх бүр үйлдвэрлэгч" дэд хөтөлбөрийн талаар: Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Хэрэглэгчээс-үйлдвэрлэгч аймаг болох зорилтын хүрээнд аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 29-ны 51 дүгээр

тогтоолоор "Өрх бүр үйлдвэрлэгч" дэд хөтөлбөрийг 2 үе шаттай явуулахаар баталсан байна. Дэд хөтөлбөр нь **"Өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэнийг тодорхойлж, ажилгүй иргэдэд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлж, хувиараа болон жижиг дунд бизнес эрхлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж, хөрөнгө оруулалт бүрийг ажлын байртай уялдуулах замаар шинэ ажлын байруудыг бий болгох, ядуурлыг бууруулах, өрх бүрийг үйлдвэрлэгч болон хөгжих нөхцөлийг бүрдүүлэх"** зорилготойгоор аймгийн ХХҮГ, ХХААГ, аймаг сумдын ЗДТГ-ууд хамтран боловсруулсан байна.

Тус дэд хөтөлбөрийг аймгийн ХХҮГ-ын суурь судалгаанд үндэслэн боловсруулсан бөгөөд дэд хөтөлбөрт тоон болон чанарын үзүүлэлтээр гарах хүрэх үр дүнг тооцоогүй, санхүүжилтийн эх үүсвэр хариуцан хэрэгжүүлэгч байгууллага зэргийг бүрэн тодорхойлоогүй, мэргэжлийн байгууллагуудыг хамруулан хөтөлбөрийг боловсруулаагүй байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ ЧАДААГҮЙ БАЙНА.



1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.

Аймгийн засаг даргын 2016-2020 он, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөрт суурилсан төсвийг төлөвлөөгүй байна.

Харин аймгийн засаг дарга ХНХС болон ХХҮГ-тай байгуулсан гэрээнд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг тусгасан боловч бодитой тооцоолоогүйг ХЭДС-ын хөрөнгийн тухайн жилийн батлагдсан төсвөөс харж болохоор байна.

ХЭДС-ийн орлого төлөвлөлтийн талаар: 2016-2021 онуудад ХЭДС-ийн төсвийн төслийг 11 хөтөлбөрт **6,886.6** сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Тус төлөвлөсөн төсөл хөтөлбөрт зарцуулах санхүүжилтийг өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэж холбогдох газруудад хүргүүлдэг тул хөтөлбөрүүдийг зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн тооцож байгаа гэж үзэхэд хүндрэлтэй байна. /Төсвийн төсөл, батлагдсан төсвийн судалгааг хавсралтаар оруулав/

Мөн ХЭДС-ийн орлогыг төлөвлөхдөө ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлогыг бодитоор тооцоолоогүй, төсвийн төслийг орон нутгаас боловсруулж явуулдаггүй байна. ХЭДС-аас орон нутагт тус орлогын төлөвлөгөөг шууд биелүүлэхээр хүргүүлж байгаа нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих сангийн батлагдсан төсвийг л биелүүлэх зорилготойгоос орон нутгийн бодит тооцоолол, судалгаа хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд төсвийн төслийг боловсруулахдаа зах зээлийн эрэлт, бодит тооцоололд үндэслэж ажиллах зөвлөмжийг Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлж байна.



1.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгаагүй байна.

А. ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийн талаар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 22.1-т зааснаар санг 8 эх үүсвэрээр бүрдүүлэхээр заажээ.

Аймгийн тухайд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, зээлийн эргэн төлөлт, ХБИ-ажиллуулаагүй орлогоос бүрдүүлэхээр төлөвлөдөг байна. 2016-2021 онд улсын төсвөөс **5,998.2** сая төгрөгийг баталж **5108.8** сая төгрөгийн зарцуулж **889.4** сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнийг он тус бүрээр харуулбал:

Хүснэгт 6: ХЭДС-аас орон нутагт хуваарилсан санхүүжилт

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2016	1066.4	449	617.4
2017	1035.5	966.1	69.4
2018	1283.8	1178.3	105.5
2019	1297.1	1233.2	63.9
2020	640.9	625.5	15.4
2021	674.5	656.7	17.8
Нийт	5998.2	5108.8	889.4

Хүснэгтээс харахад 2020,2021 онуудад улсын төсвөөс авдаг санхүүжилт өмнөх оноос 2 дахин буурсан нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор төсөл хөтөлбөрүүд хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэнтэй холбоотой байна. Тухайлбал :

- ❖ Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх үйлчилгээ” **13.6** сая төгрөгөөр буюу 90.6 хувиар,
- ❖ “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” **117.4** сая төгрөгөөр буюу 66.2 хувиар,
- ❖ Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” **324.1** сая төгрөгөөр буюу 92.2 хувиар тус тус буурсан байна.

Б. “Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийн талаар: ИТХ-аар батлагдсан “Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрт шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж тусгаагүй байна.



1.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг орон нутгаас хуваарилдаггүй байна.

А. ХЭДС-ийн санхүүжилтийн хуваарилалтын талаар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жил бүр баталсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр санхүүжилтийг хуваарилдаг байна. 2016-2021 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 11 хөтөлбөрт **5,998.2** сая төгрөгийг баталж улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. ХЭДС-аас зарцуулах санхүүжилтийг төсөл хөтөлбөр бүрээр ХЭҮЗ-өөс баталсан тогтоол, аймаг дахь ХЭСЗ-ийн шийдвэрээр батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулдаг байна. Нийт батлагдсан төсвөөс **2,868.5** сая төгрөг буюу 47.8%-ийг санхүүгийн эргэн төлөгдөх зээл эзэлж байна. Батлагдсан төсвөөс Малчдын хөдөлмөр эрхлэлт, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд түлхүү санхүүжилт хуваарилдаг байна.

Харин орон нутгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт шаардлагатай санхүүжилтийг ХЭДС-д хуваарилаагүй байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАР ДУНДЫН ТӨРИЙН БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБОО БҮРЭН ХАНГАГДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.



1.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн уялдаж чадахгүй байна.

Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулах байгууллага нь Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, бодлого арга зүйгээр хангах байгууллага нь ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс байна. Тус газрууд нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн бусад байгууллагууд болох МХГ, НДХ, МСҮТ, бусад мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж байна.

Аудитад ирүүлсэн баримтаас харахад ЗДТГ-нь бусад төрийн байгууллагад бодлого арга зүйгээр хангаж хамтран ажиллах байдал хангалтгүй байна. Нийгмийн бодлогын хэлтэс бусад байгууллагуудаас ирсэн тайлан мэдээг нэгтгэж холбогдох байгууллагуудад хүргүүлдгээс өөрөөр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа бодлогын түвшинд авч нэгтгэж үр дүнг тооцож ажиллаагүй байна. Мөн МСҮТ-тэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь НДХ-тэй хамтран ажиллаж байгаа байдал хангалтгүй байна. Учир нь ХЭДС-аас олгосон төлбөрүүдэд ажлын байрыг бий болгож байгаа иргэнд НДШ төлөх шаардлагыг тавьдаг ч энэ талаар тус байгууллагууд уялдаа холбоотой ажиллаж чадаагүй байна.

Мөн МСҮТ-тэй элсэлт төгсөлтийн мэдээг боловсруулж хөдөлмөрийн зах зээлд хамтарч ажиллаж байгаа нь хангалтгүй байна.

Иймд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны болон бусад байгууллагуудын үйл ажиллагааг харилцан уялдуулж, хамтран ажиллах зөвлөмжийг Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, төрийн болон хувийн хэвшлийн МСҮТ-дэд хүргүүллээ.



1.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс, орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээг бүрэн авч чадахгүй байна.

Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Хэрэглэгчээс-Үйлдвэрлэгч" чиглэлээр зорилт хэрэгжүүлэн түүнд орон нутгийн онцлогт тохирсон бодитой бүтээн байгуулалт хийж, ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүд баталж ажилласан байна.

Тухайлбал: Аялал жуулчлал, ХАА түлхүү хөгжсөн тул мөрийн хөтөлбөрт энэ чиглэлээр арга хэмжээ авахаар төлөвлөж "Архангайд үйлдвэрлэв" худалдааны төвийг барьж ашиглалт оруулж, ХЭДС-тай хамтран төсөл хэрэгжүүлсэн иргэдийг бодит ажлын байраар хангасан байна.

Харин сумдад хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд ихэвчлэн сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, модон эдлэл, оёдол хийх г.мэт өрхийн үйлдвэрлэл чиглэлээр явуулж байгаа нь тогтвортой ажлын байр нэмэгдүүлсэн гэж үзэхэд хангалтгүй юм.

Үүний нэг жишээ нь “Өрх бүр-үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрийн хүрээнд өрхөөр үйлдвэрлэл эрхлэх өөрөө өөртөө ажлын байр бий болгож байгаа иргэдийг үйлдвэрлэл үйлчилгээ явуулах ажлын байраар хангах, жижиг үйлдвэр цехүүдийг байгуулах зорилгоор аймгийн ОНХС-аас **822.0** сая төгрөгөөр **625** нэр төрлийн тоног төхөөрөмжийг бичил бизнес эрхэлдэг иргэдэд олгосон байна.

Орон нутгийн зүгээс ажил олгогчийг дэмжин ажилласан байдал хангалтгүй, үйлдвэрлэл хөгжөөгүй, зах зээл жижиг шалтгаанаар бүс нутгийн онцлогт тохирсон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Орон нутгийн удирдлагын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бүтээн байгуулалт үйлдвэрлэлийг бий болгосноор ажлын байр нэмэгдэх тул энэ талаар анхаарч ажиллах зөвлөмжийг аймгийн засаг дарга түүний харьяа НБХ-т хүргүүллээ.



1.3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын хамрах хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн аймаг дахь салбар зөвлөл 2 удаа шинэчлэгдэн байгуулагдсан байна.

2016-2019 онуудад ажилласан хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь жилд 2-3 удаа хуралдаж тайлант жилд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэлэлцэн баталж, баталсан төслийн санхүүжилтийн тайланг сонсдог байжээ. Харин 2020 онд аудитаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу төсөл хөтөлбөрт дотоод хяналт шалгалтыг хийдэг болсноос өөрөөр салбар зөвлөлийн үйл ажиллагаа өргөжөөгүй байна.

2021 онд шинээр томилогдсон салбар зөвлөл нь нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд жилд 2-3 удаа хуралдаж ХЭДС-ийн жилийн төлөвлөгөөг батлах, жилийн зарцуулалтын тайланг хянах, дотоод хяналт шалгалт хийх г.м ажлуудыг хэлэлцэн баталсан байна.

Хүснэгт 7: ХЭСЗ-ийн үйл ажиллагаа

№	Он	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудлын тоо	Урамшууллын дүн / сая.төг/
1	2017	3	3	3.4
2	2018	3	5	3.9
3	2019	3	5	4
4	2020	3	6	2.3
5	2021	3	6	3.0
НИЙТ ТОО		15	25	16.6

Аудитад ирүүлсэн баримт материалаас харахад хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь тухайн онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг батлах, зарцуулалтын тайланг сонсох, олгосон зээлийн хэрэгжилтэд дотоод хяналт хийх гэсэн үндсэн 3 чиглэлийн үйл ажиллагаанаас өөр журамд заасан бусад холбогдох заалтуудын хүрээнд тодорхой арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Тухайлбал: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогын дагуу бодлого боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулаагүй, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн

талаар бодлого боловсруулаагүй, Төр хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоог зохицуулаагүй, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт нөлөөллийн үнэлгээ хийгээгүй, Мэргэжлийн боловсролын байгууллага, ЖДҮ, ХХААГ, ГБЗХ-ийн болон бусад холбоодтой хамтран үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Иймд орон нутгийн онцлогт тохирсон зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагааг явуулж, зах зээлийн нөлөөллийн үнэлгээг хийж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд хүргүүллээ.



1.3.4. Бодлогын хэрэгжилтийг бодитой тайлагнаж, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогод хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. (Эх сурвалж: ХШҮДАХ-ийн 2022 оны 04 сарын 26-ны 09/725 тоот албан бичиг)

Аймгийн СХАА-аас 2017 онд ХЭДС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээс өөрөөр хяналт шалгалт хийгээгүй байна. Харин Төрийн аудитын газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2019 оны хөрөнгийн зарцуулалт, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн 2017-2020 оны хөрөнгийн зарцуулалтад 2 удаа аудит хийж төсөл хөтөлбөрт заасан ажлын байрыг нэмэгдүүлээгүй байна гэсэн дүгнэлтийг хүргүүлж аудит бүрээр төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

2021 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжтай Хүнсний аюулгүй байдлыг хангах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн"-д хийсэн аудитаар төрөөс баталсан үндэсний хөтөлбөрүүд болон "Өрх бүр үйлдвэрлэгч" дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд тус зөвлөмжийн биелэлтийн хугацаа болоогүй байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ,
АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ, ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГ БАГАТАЙ БАЙНА.**



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМААРАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.**



2.1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний үр дүнг тооцоогүй байна.

ХЭДСангаас 2016-2021 онуудад Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ /2016-2021 он/

Үзүүлэлт		Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Нийт
2016	Хамрагдсан хүн	999	613	1,612
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	12.0	1.3	13.3
2017	Хамрагдсан хүн	950	1417	2367
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	6.4	5.0	11.4
2018	Хамрагдсан хүн	1535	1012	2547
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	11.8	10.7	22.5
2019	Хамрагдсан хүн	1368	970	2338
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	11.0	10.5	21.5
2020	Хамрагдсан хүн	224	903	1,127
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	2.0	4.6	6.6
2021	Хамрагдсан хүн	868	930	1,798
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	5.9	5.1	11.0
НИЙТ	Хамрагдсан хүн	5944	5845	11789
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	49.1	37.2	86.3

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд **11789** хүнийг хамруулж, **86.3** сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ хугацаанд нийтлэг үйлчилгээнд хамрагдсан нэг хүнд ногдох дундаж зардал **7320** төгрөг байна. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хоёр арга хэмжээнд 2016-2021 онд зарцуулсан хөрөнгийн задаргааг үзэхэд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д **49.1** сая төгрөгийг буюу “Ажилд зуучлах үйлчилгээ”-ээс их хөрөнгийг зарцуулж бүлгээр **4060**, ганцаарчилсан **1884** хүнийг хамруулсан байна.

Харин ажилд зуучлах үйлчилгээнд **37.2** сая төгрөгийг **5845** иргэнд зарцуулсан байна. Анхан шатны баримтаас харахад ажилд зуучлуулсан иргэнийг тухайн ажлын байранд ажиллаж байгааг нотлох баримтгүй, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан иргэдийн үр дүнг тооцоогүй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ болон сургалтын үр дүнг тооцох, ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн нотлох баримтыг бүрдүүлж ажиллах зөвлөмжийг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлж байна.



2.1.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн ашиглалт хангалтгүй, бүртгэл, тоо мэдээ үнэн зөв гарахгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн тоо мэдээлэл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгийн шинээр бий болсон ажлын байрны тоо, сум хөгжүүлэх сан болон жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох чиглэлээр олгосон зээлийн үр дүнд шинээр бий болсон ажлын байрны тооны нийлбэрээр илэрхийлэгдэж байна.

Хөдөлмөрийн хэлтсийн ЭЛЭМИЭС (LMIS) программд улсын хэмжээнд Архангай аймгийн харьяалалтай хүн ажлын байртай болсныг нэгтгэн бүртгэдэг тул зөвхөн тухайн орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулсан ажлын байрыг тусгаарлаж үзэх боломжгүй байна.

Энэ программд аймгийн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэд, үйлдвэр дээрх сургалтанд хамрагдсан иргэдийн нэрсийг байнгын ажлын байртай болсноор бүртгэж байгаа тул аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар нийт хэдэн иргэн байнгын ажлын байртай болсныг тодорхойлох боломжгүй байна.

Өөрөөр хэлбэл зөвхөн аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар бий болсон ажлын байрны мэдээлэл, ажлын байранд байнгын тогтвортой ажиллаж байгаа эсэх мэдээллийг аймгийн НДХ-тэй уялдуулж тайлагнадаг байх шаардлагатай байна. / ХЭДС-ийн 2018,2019 оны тайлангаас/.

Аудитын явцад 2020, 2021 онуудад шинээр ажлын байр бий болсон эсэх, ажилд зуучлагдсан байдал зэргийг тулган шалгах гэсэн боловч программ гацалт ихтэй, мэдээлэл боловсруулалт удаан, иргэдийн мэдээлэл 3 сар болоод идэвхигүй төлөвт шилждэг, мэдээ мэдээлэл үнэн зөв гардаггүй, гараас оруулах мэдээлэл ихтэй байдал ажиглагдаж иргэдийн мэдээллийг бүрэн авч чадахгүй байдалд хүрч байлаа. Тус программыг цаашид бүрэн ашиглахын тулд холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас мэдээ тайланг татах, интернэт орчинд гацалтгүй хурдан шуурхай ажилладаг болгох зэрэг системийн шинэчлэлийг яаралтай хийх шаардлагатай байна. Ингэснээр хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийн бүртгэл, тоон мэдээ, үнэн зөв гарах бололцоотой байна.



2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бүрэн тооцохгүй байна.

Аудитын баг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, зуучлах үйлчилгээний 2020-2021 оны баримт материалыг шалгахад дараах байдалтай байна.

2020 онд:

- ❖ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 2.0 сая төгрөгийг гарын авлага бэлтгэж ХХҮГ-аас сургалтыг

онлайн хэлбэрээр зохион байгуулж ганцаарчилсан 147 иргэнд, бүлгээр 77 суралцагчид хамрагдсан байна./Сургалтын үр дүнг тооцоогүй/

- ❖ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогч байгууллагаас 951 ажлын байрны захиалга авч 930 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал: Хөдөө аж ахуй- 174, боловсруулах үйлдвэрлэл-95, бөөний болон жижиглэн худалдаа -18, боловсрол салбарт-86, бусад салбарууд 530 иргэн тус тус зуучлагдсан байна. /Бодит ажлын байр бий болж ажлын байр хадгалагдсан эсэхэд хяналт хангалтгүй/

2021 онд:

- ❖ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 5.9 сая төгрөгийг зарцуулж 3 сургалтын төвтэй гэрээ байгуулж, ХХҮГ-ын мэргэжилтэн Эрдэнэбулган сумын 1-р сургууль, 5-р сургууль, аймгийн 6 суманд сургалт зохион байгуулж 210 иргэнд ганцаарчилсан, 658 суралцагчид бүлгээр сургалт зохион байгуулсан байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиглэлээр аймгийн ХХҮГ-аас "Эм Эс девелопмент" ХХК, "Эл Эй Энд Си" ХХК, "Дарь овооны эзэд" ТББ-тай гэрээ байгуулан 11 сумдын ганцаарчилсан 210 иргэнд, мөн 10 сумдын 300 иргэнийг бүлгийн сургалтад хамруулж 4.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Дээрх 3 сургалтын байгууллагатай холбоотой анхан шатны баримт материалыг тулган шалгахад аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг дүгнэж байна.
- ❖ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогч байгууллагаас 999 ажлын байрны захиалга авч 961 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал: Хөдөө аж ахуй- 146, боловсруулах үйлдвэрлэл-43, бөөний болон жижиглэн худалдаа -37, боловсрол салбарт-65, бусад салбарууд 670 иргэн тус тус зуучлагдсан байна. /Бодит ажлын байр бий болж ажлын байр хадгалагдсан эсэхэд хяналт хангалтгүй/

ХХҮГ-аас сургалттай холбоотой тухайн жилийн төслийг явуулахдаа хуульд заасан чиглэлийн дагуу сургалтыг зохион байгуулдаг хэдий ч ямар сургалт илүү эрэлт хэрэгцээтэй байгаа, сургалтын үр дүнд хичнээн иргэн ажлын байртай болсон, мэргэжил сонголтгоо зөв хийж, өөрийгөө илэрхийлэх чадвар эзэмшсэн зэрэгийг тооцож ажилладаггүй байдал ажиглагдлаа.



ЗАСГИЙН ГАЗРААС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.



2.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байрыг нэмэгдүүлэх ажилгүйдлийг бууруулахаар орон нутагт ЖДҮХС-аас болон СХС-аас олгосон зээл, аймгийн ИТХ-аар 2018 онд батлагдсан “Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.

ЖДҮХС-аас зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлсэн байдал:

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас ЖДҮХС-аас зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлсэн байдалд 2019, 2019-2020 онуудад 2 удаа аудит хийсэн байна. ЖДҮХС-аас 2016-2020 онуудад олгосон зээлийг харуулбал:

Хүснэгт 9: ЖДҮХС-ийн хөрөнгө, ажлын байр нэмэгдсэн байдал /сая.төг, хүн/

№	Он	Төслийн зориулалт		Нэмэгдсэн ажлын байрны тоо		Аудитын дүн дүгнэлт
		Тоо	Санхүүжилт	Байнгын /6 сараас дээш/	Түр /6 сараас доош/	
1	2016	Төсөл хэрэгжүүлээгүй				
2	2017	Төсөл хэрэгжүүлээгүй				
3	2018	9	410.0	2	18	Төсөл сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилт хангалтгүй, зарим зээлийг зориулалт бусаар зарцуулсан
4	2019	20	1,500.0	20	25	Төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй ч зээлийг зориулалтын дагуу зарцуулж байна.
5	2020	5	500.0	8	3	
6	2021	Төсөл хэрэгжүүлээгүй				
НИЙТ ДҮН		34	2,410.0	30	46	

*/Эх сурвалж: 2018,2020 онуудад гүйцэтгэсэн аудитын тайлан/

Архангай аймагт ЖДҮХС-аас 2018-2020 онуудад 34 төсөл хэрэгжүүлэгч иргэн ААНБ-уудад **2,410.0** сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд төсөл хэрэгжүүлснээр байнгын **30**, түр **46** ажлын байраар хангасан мэдээлэлтэй байна.

- ❖ 2019 онд гүйцэтгэсэн “Архангай аймгийн ХХААГ-ын жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2016-2017 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн аудитаар **“Төсөл сонгон шалгаруулах журмын хэрэгжилт хангалтгүй, зарим төсөл хэрэгжүүлэгч олгосон зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна.”** гэсэн дүгнэлт хийж дотоод хяналт үйл ажиллагааг сайжруулах 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.
- ❖ 2020 онд гүйцэтгэсэн “Архангай аймгийн ХХААГ-ын жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдалд”-д давтан аудит хийж **“Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна”** гэсэн дүгнэлтийг хийж өмнөх аудитаар хүргүүлсэн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага, үйл ажиллагааг сайжруулах 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.

Дээрх аудитаар төсөл хэрэгжүүлэгч нарын ажлын байр хадгалалтыг бодит байдал дээр очиж шалгахад төсөлд заасан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, төслийг зориулалт бусаар зарцуулсан, түүнд тавих хяналт хангалтгүй байсан байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үр дүнд ажлын байрыг нэмэгдүүлсэн байдал.

Сум хөгжүүлэх сангаас зээл олгосон байдалд Төрийн аудитын газраас 2016 онд нэгдсэн төлөвлөгөөт **“Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн”-д** нийцлийн аудит хийгдсэнээс өөрөөр ажлын байр нэмэгдүүлсэн байдалд аудит хийгдээгүй байна.

Хүснэгт 10: СХС-аас ажлын байр нэмэгдсэн байдал /хэмжих нэгж: сая. төг, хүн/

№	Онууд	Төсөл авсан иргэдийн тоо	Ажлын байрны тоо	Нэмэгдсэн ажлын байрны тоо		Авсан зээлийн хэмжээ / сая. Төг/	Нийт хүү	Нийт төлөх /үндсэн зээ+хүү/	Төлсөн / сая. Төг/	Үлдэгдэл / сая төг/
				Байнгын /6 сараас дээш/	Түр /6 сараас доош/					
1	2016	280	355	141	214	1,025.2	57.1	1,082.3	900.4	163.4
2	2017	415	523	257	266	1,241.9	74.8	1,335.2	1,141.9	204.1
3	2018	374	500	254	246	1,583.6	101.4	1,685.0	1,329.0	365.7
4	2019	457	492	277	215	1,368.3	98.5	1,454.5	934.9	648.7
5	2020	512	463	260	233	1,620.5	99.5	1,715.8	524.1	1,196.7
6	2021	188	271	156	115	1,042.9	60.2	1,103.0	58.9	1,105.5
	Нийт дүн	2226	2604	1345	1289	7,882.4	491.5	8,375.9	4,889.2	3,684.1

*Эх сурвалж: Сумдаас ирүүлсэн судалгаа

Хүснэгтээс харахад 2016-2021 онуудад нийт 2226 иргэн **7,882.4** сая төгрөгийн зээлийг СХС-аас авч 2604 ажлын байр бий болсноос **1345** байнгын, **1289** түр ажлын байрыг бий болгосон гэж мэдээлжээ.

Гэвч бодит байдал дээр ажлын байр нэмэгдээгүй төслийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрлээ. Аудитын баг СХС-аас олгосон зээлийн 2020-2021 онуудын зарцуулалт ажлын байр нэмэгдсэн байдалд аймгийн 10 сумдыг түүвэрлэн газар дээр нь очиж танилцахад ЗГ-ын 2016 оны 153 тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”²-ын 4.3.6³-т заасан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, НДШ төлөөгүй, 5.3.3⁴-т заасны дагуу сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Хүснэгт 11: Сум хөгжүүлэх сангаас олгосон санхүүжилт / хэмжих нэгж: сая. төг, хүн/

№	Он	Сумын нэр	СХС-аас авсан зээл		Зориулалт бус зарцуулсан		Зөрчсөн эрх зүйн акт
			хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	мөнгөн дүн	
1	2020	Цахир	17	56	8	20	МУЗГ-ын 2016 оны 153-р тогтоолын 4.3.6, 5.3.2, 6.1 дахь заалт
2		Тариат	36	173	0	-	
3		Ихтамир	15	79	0	-	
4		Цэцэрлэг	12	103	0	-	
5	2021	Эрдэнэмандал	15	220	4	95	
6		Жаргалант	15	124	2	55	
7		Чулуут	29	163	0	-	
8		Хангай	13	51	0	-	
9		Өндөр-Улаан	84	236	0	-	
10		Булган	12	90	0	-	
	НИЙТ ДҮН		248	1,294	14	170.0	

² ЗГ-ын 2022 оны 81-р тогтоолоор хүчингүй болсон.

³ 4.3.6 ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

⁴ 5.3.3. аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжийн хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлэх.

Дээрх 10 сумын зээл авсан 248 иргэд төсөлдөө 2-3 ажлын байр нэмэгдүүлсэн гэх боловч зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй, төсөлд заасан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, зээл авсан иргэн НДШ төлж ажлын байр нэмэгдүүлээгүй байна.

Тиймээс сумдаас ирүүлсэн судалгаа болон сумдын хөдөлмөр халамж үйлчилгээний байгууллагуудын жил бүр гаргадаг мэдээг бодитой гэж үзэхэд учир дутагдалтай байна.

“Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрөөр ажлын байр нэмэгдсэн байдал:

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ны 51 дүгээр тогтоолоор “Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрийг баталсан байна. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгаас тусгайлан төсөв батлаагүй, түүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүйг 1-р бүлэгт дурдсан.

Тус дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар нийт 16 зорилт арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 85%-тай гэж дүгнэсэн байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн үйлдвэрлэлийг бодитоор нэмэгдүүлж ажлын байр бий болгосон нь тодорхойгүй байна. Мөн аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж ажилласан гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.


Дэд хөтөлбөрийн хүрээнд ОНХС-аас 8 суманд 822.0 сая төгрөгийн 625 төрлийн хөрөнгийг иргэдийн ажлын байрыг дэмжихээр олгосон байна. /Тус асуудал АТГ-т шалгагдаж байгаа тул нарийвчлан шалгаагүй болно./



2.2.2 ЖДҮХС, Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн ажлын байрны мэдээлэл бодитой бус, түүний үр дүнг бодитоор тайлагнаж чадахгүй байна.

ЖДҮХС-аар ажлын байр нэмэгдүүлсэн байдлыг түүвэрлэн 2019,2020 оноор харуулбал: /Эх сурвалж: Архангай аймгийн ХХААГ-ын жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдалд”-д хийсэн аудитын дүнгээс/

“Тайхар Милко” ХХК



Зураг 1: Алату үүлдрийн үхэр

Фермерийн үйл ажиллагааг өргөжүүлэн үйлдвэрлэлийн байр шинээр барих 2019 онд үнээний фермерийн үйл ажиллагаандаа зориулж Алатау үүлдрийн сүүний 15 үнээ болон малын өвс, тэжээл, түүхий эд материал худалдан авах зориулалтаар **103.7** сая төгрөгийн төсөл ирүүлж, **50.0** сая төгрөгөөр батлагдсан байна.

Төсөлд тусгагдсан санхүүжилтээ бүрэн авч чадаагүй хэдий ч үнээгээ худалдаж аваад үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ хийсэн 13 хүүхдийн цэцэрлэг, Ихтамир сумын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа нь зогссонтой

холбоотой хүндрэл бэрхшээлтэй асуудал тулгарсан байна. Одоогийн байдлаар 4 ажлын байр бий болгосон байна.

"Уламбаяжихуй" ХХК "Өдөр бүр-Шинэ хүнс" төсөл



Зураг 2: Үйлдвэрийн барилга

2019 онд үйлдвэр үйлчилгээний барилга барих **200.0** сая төгрөгийн төсөл ирүүлж, дэмжигдэн зээл авсан. Эрдэнэбулган сумын 2-р баг Дэмид жанжны гудамж 1-108 "Фламинго" рестораныг ашиглалтад оруулж, төсөлд тусгагдсан **20** хүнийг ажлын байраар ханган ажиллаж, НДШ-ийг бүрэн төлж байна.

"Наймган тал Дэйри" ХХК "Цагаан идээний бүрэн автомат үйлдвэр байгуулах" төсөл



Зураг 2: Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн

2019 онд цагаан идээг олон төрлөөр үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах, түүхий эд худалдан авах **150.0** сая төгрөгийн төсөл ирүүлж, 120.0 сая төгрөгөөр дэмжигдэн зээл авч Эрдэнэбулган сумын 7-р багийн 25-2520 тоотод үйлдвэр үйлчилгээг явуулж, төсөлд тусгагдсанаар байнгын **4** ажлын байр, түр **9** ажлын байрыг бий болгоод НДШ-ийг төлдөг байна. 2021 онд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй учраас аудитаас зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах, хяналт тавих албан шаардлага хүргүүлж ажиллахаар шийдвэрлэсэн байна.

ЖДҮХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан **25** иргэн, аж ахуйн нэгжийн хадгалсан болон шинээр бий болгосон ажлын байрыг нийгмийн даатгалын байгууллагад мэдээлж, баталгаажуулсныг тулган шалгахад тухайн зээлдэгчийн ажиллагсдын бодит тоог нотлох боломжгүй байна. Төслийн хүрээнд зээлдэгч нар **116** ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор шинээр **56** ажлын байрыг бий болгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүрээнд ажлын байр нэмэгдүүлсэн байдлыг түүвэрлэн 2020,2021 оноор харуулбал: /Аймгийн баруун хойд 10 сумдад ажилласан тайлан/

1. Жаргалант сум: 2020 онд 1 удаагийн шийдвэрээр **15** иргэнд **124.0** сая төгрөгийн олгосон байна. Зээлийн ашиглалтын байдлыг шалгахад 2 иргэн **55.5** сая төгрөгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
2. Ихтамир сум: 2020 онд 2 удаагийн шийдвэрээр **15** иргэнд **78.5** сая төгрөгийн зээл олгосон байна. Төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
3. Эрдэнэмандал сум. 2020 онд 1 удаагийн шийдвэрээр **15** иргэнд **220.0** сая төгрөгийн зээл олгосон байна. Зээлийн ашиглалтын байдлын шалгахад 4

- иргэн **95.0** сая төгрөгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
4. Цахир сум: 2020 онд 1 удаагийн шийдвэрээр **17** иргэнд **56.0** сая төгрөгийн зээл олгосон байна. Өрхийн амьжиргааг дэмжсэн тул төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
 5. Тариат сум: 2020 онд 2 удаагийн шийдвэрээр **36** иргэнд **173.0** сая төгрөгийг олгосон байна. Төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
 6. Чулуут сум: 2021 онд 3 удаагийн шийдвэрээр **29** иргэнд **163.0** сая төгрөгийн зээлийг олгосон байна. Өрхийн амьжиргааг дэмжсэн тул төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
 7. Цэцэрлэг сум: 2021 онд 5 хөтөлбөр хэрэгжиж **30.2** сая төгрөгийн зээл олгосон байна. Зээл авсан **6** иргэн нийт **9** ажлын байр бий болохоор төсөлд тусгаж байнгын **8** ажлын байр бий болгосон. ИТХ-аас хяналт хийгдээгүй,
 8. Өндөр-Улаан сум: 2021 онд СХСангаас 3 удаагийн шийдвэрээр **84** иргэнд **236.8** сая төгрөгийн олгосон байна Өрхийн амьжиргааг дэмжсэн тул төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.
 9. Хангай сум: 2021 онд СХСангаас 1 удаагийн шийдвэрээр **13** иргэнд **51.0** сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Өрхийн амьжиргааг дэмжсэн тул төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй
 10. Булган сум: 2021 онд СХС-аас 13 иргэнд 90.0 сая төгрөг олгосон байна. Өрхийн амьжиргааг дэмжсэн тул төсөлд тусгагдсан ажлын байрыг нэмэгдүүлээгүй, хяналт хийгдээгүй.

Сумдад ажиллахад СХС-аас олгосон зээлийг хэт жижиглэж өрхийн үйлдвэрлэл маягаар олгож байгаа нь ажлын нэмэгдэхгүй, түүнд сумын ИТХ болон холбогдох байгууллагуудын зүгээс хяналт тавьдаггүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй зэрэг олон алдаа зөрчил илэрч байна. Энэ байдал бүх сумдад гарахаар байгаа бөгөөд төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт бий болж байна.

Аудитаас сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байж болзошгүй, ажлын байр нэмэгдүүлээгүй, байнгын хяналт шалгалт хийж үр дүнг тайлагнаагүй дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлээ.

СХС-аас олгож байгаа зээлээр ажлын байр нэмэгдэж байна гэж сумдын ХАА, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүдийн мэдээлж байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна.



2.2.3. ХХҮГ-аас 2016-2020 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2021 онд ХХҮЕГ-ын дарга, аймгийн ХХҮГ-ын даргын 2020 оны 22 тоот Орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэх гэрээгээр орон нутгийн зорилтот бүлгийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор 6 сургалтын байгууллага 10 удаагийн сургалтаар өрх толгойлсон **555** эмэгтэйчүүд хамрагдаж сургалт хоолны зардалд **28.3** сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдээс 58 өрх толгойлсон эмэгтэйг “Гост” ХХК, “Бүрэн Ар” ХХК, “Уламбаяжихуй” ХХК зэрэг газруудад 45 хоногийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллуулж, үүнээс 28 эмэгтэйг байнгын ажлын байраар хангасан байна.

ХЭДС-аас зээл авсан иргэдийн хүйсийн харьцааг авч үзвэл нийт зээл авсан иргэдийн 75 орчим хувь нь эмэгтэйчүүд байна. Авсан төслөөс харахад оёдол, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл зэрэг төслүүдийг эмэгтэйчүүд бичиж авдаг байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН (ХЭДС)-ГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛИЙН ДАГУУ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ Ч ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ БАЙНА.



2.3.1. ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлж байгаа ч ХБИ- ажиллуулаагүй төлбөрийн орлого бодитоор төвлөрөхгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1-д зааснаар ХЭДС нь 9 төрлийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд манай аймгийн тухайд хуулийн 22.1.1-д заасан “улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө”, 22.1.7-д заасан “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр”, 22.1.8-д заасан “жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө”-өөс орлогыг төвлөрүүлж байна.

Хүснэгт 12: 2026-2021 онуудад эргэн төлөгдөх санхүүжилт олгосон байдал / хэмжих нэгж сая.төг, хүн/

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ		2021.12.31-ны үлдэгдэл		2022.12.31-нээр төлж барагдуулах		Хугацаа хэтэрсэн		Найдваргүй		Хуулийн байгууллагад хандсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажлын байрыг дэмжих	346	1,033.50	154	38.93	56	102.2	9	9.64	0	-	9	9.64
2	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	44	343	23	141.2	16	87.7	4	17.55	0	-	4	17.55
3	Малчдын хөдөлмөр эрхлэлт	311	1,186.00	96	217.82	75	131.2	9	23.96	0	-	8	23.86
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих	86	236	70	192.64	13	12.5	5	6.02	-	-	5	6.02
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	53	111	31	76.99	14	9.3	2	2.1	1	1.05	1	1.05
6	Орон нутгийн онцлог хэрэгцээ	43	300	11	72.96			11	41.44	-	-	11	41.44
	Нийт дүн	883	3,209.50	385	740.53	174	342.9	40	100.7	1	1.05	38	99.55

2021 оны 12 сарын 31-ны байдлаар хугацаа хэтэрсэн, найдваргүй зээлийн үлдэгдэл 100.7 сая төгрөг байгаа бөгөөд 38 зээлдэгчтэй холбоотой 99.5 сая төгрөгийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн байна.

Харин аудитаас 2022 оны 12 сарын 31-ны байдлаа барагдах 174 иргэнтэй холбоотой 372.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтрэлт, найдваргүй зээл үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс холбогдох арга хэмжээг тухай бүрд нь авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2018 оны 9 сарын 04-ны 128 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, Хөдөлмөрийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан ЗГ-ын 2009 оны 1 сарын 28-ны 26 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, хуулийн 111.1, 111.2, 111.3 дахь заалтыг өмчийн хэлбэр үл харгалзан бүх байгууллагууд хэрэгжүүлэхээр байна.

2016-2021 онуудад ХБИ ажиллуулаагүй 24 иргэн ААНБ-аас нийт **36.6** сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13: 2026-2021 онуудад ХБИ орлого төвлөрсөн байдал.

2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулдаг 25 ба түүнээс дээш ажилтантай нийт 111 байгууллагад 242 ХБИ ажиллахаас 170 иргэд ажиллаж, 45 байгууллагад 72 иргэдийг зохих ёсоор ажиллуулаагүй байна.

№	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлсөн байгууллагын тоо
	2016	8.0	-	0
2	2017		1.7	3
3	2018	1.0	1.0	4
4	2019	1.2	8.1	9
5	2020	2.5	19.8	7
6	2021	2.5	6.0	1
НИЙТ ДҮН		15.2	36.6	24

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ХАБЭА хариуцсан мэргэжилтэн тус

хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа хэдий ч тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Иймээс тус орлого бодит хэмжээгээр төвлөрөх боломж бүрддэггүй байна.

Иймд ХБИ-г ажиллуулаагүй төлбөрийн орлогыг зохих ёсоор санд төвлөрүүлж ажиллах эсвэл 2022 оны 01 сарын 1-ны өдрөөс мөрдөж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалтыг хэрэгжүүлж хуулийн хэрэглээг сурталчлах үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж ажиллах зөвлөмж ХХҮГ-т хүргүүлж байна.



2.3.2. ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан ч төсөлд заасан ажлын байрыг бодитоор бий болгоогүй, НДШ төлөлт хангалтгүй байна.

ХЭДСангаас 2016-2021 онд нийт 11 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж **4,921.3** сая төгрөгийг зарцуулж **18935** иргэнийг хамруулсан байна.

Хүснэгт 14: 2016-2021 онуудад ХЭДС-ын төсөл хөтөлбөрийн зарцуулалт /хэмжих нэгж: сая. төг, хүн/

№	Хөтөлбөрийн нэр	Санхүүжилт, хамрагдсан хүний тоо	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт дүн
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	хүний тоо	999	950	1,535	1,368	224	868	5,944
		санхүүжилт	12.0	6.4	11.8	11.0	2.0	5.9	49.2

2	Ажилд зуучлах үйлчилгээ	хүний тоо	613	1,417	1,012	970	903	930	5,845
		санхүүжилт	1.3	5.1	10.7	10.5	4.6	5.1	37.3
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	хүний тоо	105	175	193	239		271	983
		санхүүжилт	16.4	28.5	22.8	34.5	-	21.0	123.1
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	хүний тоо	614	1,013	579	804	496	482	3,988
		санхүүжилт	212.6	433.9	291.1	503.8	368.8	277.3	2,087.6
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	хүний тоо	64	111	96	110	9	81	471
		санхүүжилт	32.7	81.0	87.9	165.5	57.0	39.8	463.9
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	хүний тоо	24	158	241	188	81	75	767
		санхүүжилт	108.0	281.4	321.8	349.3	27.4	100.0	1,188.0
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	хүний тоо	75	111	138	128	25	72	549
		санхүүжилт	39.4	58.4	66.9	67.1	76.0	113.3	421.1
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	хүний тоо	20	41	34	29	26	27	177
		санхүүжилт	4.0	40.4	31.2	39.6	34.3	37.1	186.6
9	Орон нутгийн онцлогтой зорилтот төслийн санхүүжилт	хүний тоо			43				43
		санхүүжилт	-	-	300.0	-	-	-	300.0
10	Хүүхэд хамгаалагч төсөл	хүний тоо				2	2	2	6
		санхүүжилт	-	-	-	4	3	2	9
11	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	хүний тоо					162		162.00
		санхүүжилт	-	-	-	-	22.4	33.1	55.5
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дүн		хүний тоо	2,514	3,976	3,871	3,838	1,928	2,808	18,935
		санхүүжилт	426.4	935.1	1,144.4	1,185.3	595.1	635	4,921.3

Төрийн аудитын газраас 2019 он хүртэл ХЭДС-аас зарцуулсан хөрөнгийн зарцуулалтад аудит хийж үр дүнг тухай бүр тайлагнаж ажилласан тул 2020-2021 онуудад ХЭДС-аас зарцуулсан хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар шалгаж төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн **10** сумын **46** иргэд, ААН-ийн **276.6** сая төгрөгийн үйл ажиллагааг газар дээр нь очиж шалгалаа.

Аудитад хамрагдсан төсөл хөтөлбөрийг сумдаар танилцуулбал:

1. Чулуут сум: 38.0 сая төгрөгийн 8 төсөлд 20 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.
2. Хангай сум: 14.0 сая төгрөгийн 3 төсөлд 7 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй
3. Цахир сум: 20.0 сая төгрөгийн 5 төсөлд арга хэмжээг хэрэгжүүлж 12 ажлын байрыг бий болохоор төсөлд тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөггүй. Мөн ажил олгогчийн урамшуулалаар 1 компанид 13.6 сая төгрөгийн урамшууллыг олгосныг НДХ-ээс ирүүлсэн баримтад үндэслэн шалгахад 2020 онд 3 ажлын байрыг бий

болгосон ч 2021 оноос тус иргэлийн НДШ-г төлөөгүй, үргэлжлүүлэн ажиллуулаагүй байлаа.



Зураг 4: /Цахир суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд/


4. Өндөр-улаан сум: 27.0 сая төгрөгийн 7 төсөлд 9 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.
5. Эрдэнэмандал: 16.5 сая төгрөгийн 6 төсөлд 15 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.



Зураг 5: Эрдэнэмандал суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд/

6. Цэцэрлэг: 22.0 сая төгрөгийн 5 төсөлд 16 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.
7. Жаргалант: 23.0 сая төгрөгийн 3 төсөлд 7 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.
8. Тариат: 24.0 сая төгрөгийн 7 төсөлд 10 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.
9. Булган сум: 22.0 сая төгрөгийн 6 төсөлд 10 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй.

10.Ихтамир сум: 12.5 сая төгрөгийн 4 төсөлд 12 ажлын байрыг бий болохоор тусгасан боловч өнөөдрийн байдлаар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хангалтгүй, цалингийн цэс болон бусад нотлох анхан шатны баримтгүй, НДШ төлөгдөөгүй. Мөн ажил олгогчийн урамшууллаар 1 компанид 13.3 сая төгрөгийн урамшууллыг олгосныг НДХ-ээс ирүүлсэн баримтад үндэслэн шалгахад 2020 онд 3 ажлын байрыг бий болгосон ч 2021 оноос тус иргэдийн НДШ-г төлөөгүй, үргэлжлүүлэн ажиллуулаагүй байлаа



Зураг :6 Ихтамир суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд

Төслийн санхүүжилтийг авснаар бодит ажлын байр бий болоогүй, зөвхөн өрхийн үйлдвэрлэлийг дэмжсэн, төсөл авсан иргэн НДШ төлдөггүй гэх мэт зөрчлүүд илэрч байна. Энэ нь ХЭДС-аар бодит ажлын байр бий болсон гэж үзэхэд хүндрэлтэй юм. Мөн ХЭСЗ-өөс баталсан санхүүжилтийг иргэдэд тэгш хүртээмжтэй олгох зорилгоор төслийг жижиглэж байгаа нь ажлын байр бодитоор нэмэгдэхгүй байх нэг шалтгаан болж байна.

ХЭДС-аас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд өмнөх аудитаар илэрч байсан анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу хөтөлбөрийн шалгуур хангаагүй иргэдэд санхүүжилт олгодог байсан зөрчил арилсан байна. Аудитаас хүргүүлсэн шийдвэрийн дагуу төсөл хэрэгжүүлэгч иргэдээс санхүүжилт олгосоноос 3 сарын дотор төслийн зарцуулалтыг нотлох баримтын хамт авч зээлийн эргэн төлөлтийн талаар мэдэгдэл хүргүүлж ажиллаж байгаа ч **хөдөлмөр халамж үйлчилгээний газрын зүгээс төслийн үр дүн буюу ажлын байранд анхаарал хандуулдаггүй, энэ талаар тавих хяналт хангалтгүй** байна.

Иймд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлээгүй 276.6 сая төгрөгийн зөрчилд бодит ажлын байрыг бий болгож НДШ төлөхөд анхаарч ажиллах ажиллаж албан шаардлагыг Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт хүргүүллээ.



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САН (МБСДС) БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГААС ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР НӨЛӨӨ МУУ БАЙНА.



2.4.1. МБСДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу үр ашигтай зарцуулж, үр нөлөөг тооцоогүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх нэг гол эх үүсвэр нь ХЭДС юм. Энэхүү сангийн хөрөнгийн бараг тал хувийг гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлсөн ажлын байрны төлбөрөөс бүрдүүлж, тус сангийн хөрөнгийн 23 орчим хувийг МБСДС-г санхүүжүүлэхэд зориулж байна.⁵

ЗГ-ын 2012 оны 94-р тогтоолын 4-р хавсралт “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг сурагчид ноогдох хувьсах зардлын дундаж норм” тооцох аргачлалын дагуу МБСДС-аас өмчийн хэлбэр харгалзахгүйгээр суралцагчдын хувьсах зардлыг олгодог байна. Манай аймгийн тухайд нэг хүүхдэд ноогдох хувьсах зардалд 605.8 мянган төгрөгийн санхүүжилт авдаг бөгөөд төрийн өмчийн бус 2 /Булган, Гурвантамир МСҮТ/ байгууллага тус сангаас 100% санхүүждэг байна. Харин төрийн өмчит 1 /Архангай/ МСҮТ улсын төсвөөс санхүүжилт авч байна.

Үйл ажиллагаа явуулдаг 3 МСҮТ-д сүүлийн 5 жилд **5976** суралцагчид сурж, **7,911.2** сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт 15: МСҮТ-ийн санхүүжилт, хүүхдийн тоо / хэмжих нэгж: сая.төг, хүн/

№	Хичээлийн жил	Архангай МСҮТ		Гурван тамир МСҮТ		Булган МСҮТ		Нийт	
		Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт
1	2016-2017	472	906.2	160	96.7	300	296.6	932	1299.5
2	2017-2018	460	929.5	255	154.5	277	266.7	992	1350.7
3	2018-2019	472	955.6	370	224.5	405	377.7	1247	1557.8
4	2019-2020	509	1202.8	394	238.7	438	312.7	1341	1754.2
5	2020-2021	562	1495.8	310	188.0	412	265.2	1284	1949
НИЙТ ДҮН		2475	5489.9	1489	902.4	1832	1518.9	5796	7911.2

Нийт сургалтын байгууллагуудад хувьсах зардлын нормативыг жигд ашиглахгүй байгаа нь хувийн болон төрийн өмчийн сургалтын байгууллагын хооронд **санхүүжилтийн хуваарилалтын ялгаа бий болгож, тэгш байдал алдагдаж, төрийн өмчийн сургалтын байгууллагуудын бие даасан, үр ашигтай, үр дүнтэй үйл ажиллагаа явуулах идэвхийг сулруулж байна.** Тухайлбал, төрийн өмчийн сургалтын байгууллагуудын сургалтын чанар, төгсөгчдийн ур чадвар эзэмшсэн байдал болон ажилтай болсон байдал, бусад үйл ажиллагааны үр дүнгээс үл хамааран төсвийг олгож байна.⁶

Энэ байдал ч манай аймагт харагдаж байгаа бөгөөд улсын МСҮТ-ийн санхүүжилт суралцагчийн тооноос үл хамааран жил бүр өсөж байгаа хандлага байна.

Харин хувийн МСҮТ-үүд суралцагчийн хувьсах зардлаар санхүүждэг тул элсэлт түлхүү авах сонирхолтой байдал ажиглагдаж байна.



2.4.2. МБС-ын байгууллагын санхүүжилт үр нөлөөтэй бага байна.

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд 2014 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2015 оны нэгдүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

⁶ Монгол улсын мэргэжлийн боловсрол, сургалтын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох нь” УБ 2021 он. 21-тал

Үйл ажиллагаа явуулдаг 3 МСҮТ-д сүүлийн 5 жилд **5976** суралцагчид сурч, **7,911.2** сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Архангай аймгийн тухайд нэг хүүхдэд ноогдох хувьсах зардалд 0.6 сая төгрөгийн санхүүжилт авдаг бөгөөд төрийн бус өмчийн 2 байгууллага тус сангаас 100% санхүүждэг байна. Харин төрийн өмчит 1 МСҮТ улсын төсвөөс санхүүжилт авч байна. Улсын төсвөөс санхүүжилт авдаг Архангай МСҮТ-ийн төсвөөс авдаг санхүүжилтийг нэг хүүхдэд ногдуулж үзвэл **2.2** сая төгрөг буюу хувьсах зардлаас **1.6** сая төгрөгөөр илүү байна.

2016-2021 онуудад дээрх 3 МСҮТ-д нийт 4729 суралцагч төгссөн байна.

Хүснэгт 16: МСҮТ-ийн төгсөгчид, ажлын байр

Он	Булган МСҮТ			Гурвантамир МСҮТ			Архангай МСҮТ		
	Нийт төгсөгчид	Үүнээс		Нийт төгсөгчид	Үүнээс		Нийт төгсөгчид	Үүнээс	
		Ажлын байртай	Ажилгүй		Ажлын байртай	Ажилгүй		Ажлын байртай	Ажилгүй
2017	300	199	101	115	74	41	275	174	101
2018	277	210	67	185	68	77	282	210	72
2019	405	249	156	260	201	59	350	181	169
2020	438	288	150	318	224	94	412	144	268
2021	412	198	214	283	194	79	417	205	212
НИЙТ ДҮН	1832	1144	688	1161	761	350	1736	914	822

*Эх сурвалж: МСҮТ-ээс ирүүлсэн төгсөгчдийн мөшгөх судалгаа

Нийт төгсөгчдийн 2819 буюу 60.0% орчим хувь нь байнгын ажлын байртай болсон мэдээлэлтэй байна. Төгсөгчид ихэвчлэн үйлчилгээний болон барилга, худалдааны салбарт ажилд орж байна. ХХҮГ-аас төгсөгчдийг ажлын байраар хангах, ажилд зуучлах арга хэмжээ хангалтгүй байгаа бөгөөд жилд авах элсэлт төгсөлт, ажлын байраар хангагдсан мэдээллийг албан ёсоор МСҮТ-ээс авч ажиллаагүй байна.

Энэ нь МСҮТ-ийн хэдэн сурагч зуучлалаар ажлын байранд хамрагдсан тогтвортой ажилласан эсэх асуудлуудыг нэг бүрчлэн үзэж шалгах боломжгүй байдалд хүргэж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа МСҮТ нь 10-19 мэргэжлээр мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх 1 жилийн өдрийн ангид элсэлт авч байгаа байдал ажиглагдлаа. Тухайлбал:

- ✓ Гурван тамир МСҮТ- 10 мэргэжлээр
- ✓ Булган МСҮТ-13 мэргэжлээр
- ✓ Архангай МСҮТ-19 мэргэжлээр тус тус элсэлт авч байна.

Элсэлтийн мэргэжлүүдийг харахад /элсэлт давхардсан байдал/ зах зээлд эрэлт ихтэй барилга болон үйлчилгээний салбарт түлхүү байна.

МСҮТ-д суралцагчдын тоо 2018-2020 оны хичээлийн жилээс нэмэгдсэн бөгөөд энэ нь төрөөс олгодог тэтгэлгийн хэмжээг **100.0** мянган төгрөг, 2019-2020 оны хичээлийн жилээс **200.0** мянган төгрөг болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой. Үүнээс шалтгаалан чадамжид суурилсан 1 жилийн ангид суралцах явдал ихэссэн байна.

Тухайлбал:

- ✓ 2018-2019 оны хичээлийн жилд ЗГ-ын 2019 оны 12-р тогтоолоор МСҮТ-д суралцагчдад тавих үндсэн шаардлага нь зөвхөн цахим системд бүртгэгдсэн, ирц 75 хувиас доошгүй байх гэсэн шаардлага тавигдсанаар өмчийн хэлбэр үл харгалзах байгууллагад ажиллаж байгаа ямар ч насны иргэд суралцах боломжийг бүрдүүлснээс батлагдсан квотод өөрчлөлт орсон байна. Мөн ажил эрхэлж байгаа иргэдэд тэтгэлэг олгож эхэлсэн байна.
- ✓ 2019-2020 оны хичээлийн жилд ЗГ-ын 2020 оны 44-р тогтоолоор МСҮТ-д суралцагчдад насны хязгаар тогтоон /45 хүртэл/, албан журмын НДШ төлдөггүй иргэдийг суралцуулах болсноор хувийн МСҮТ-д суралцагчдын тоо бага зэрэг буурсан боловч тэтгэлгийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалан өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг, НДШ сайн дураар төлдөг иргэд суралцах байдал нэмэгдсэн байна.

Энэ нь нэг талаар чадамжийн гэрчилгээтэй мэргэшсэн ажилтан бэлтгэгдэх сайн талтай ч нөгөө талаараа ажил эрхлэх сонирхолгүй, сургалтад хамрагдах нэрээр тэтгэлэг авах асуудал үүсгэж байна. Учир нь 1 жилийн ангид суралцаж төгсөөд үргэлжлүүлэн өөр МСҮТ-д сурч байгаа байдал судалгаанаас ажиглагдсан бөгөөд тус суралцагчийг тэтгэлэг давхардуулан авсан эсэхийг тулгах боломжгүй байна. Энэ нь 2019 оноос хойш тэтгэлэг нь суралцагчийн данс руу шууд ордогтой холбоотой байна.

Иймд ХНХС-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж, аймгийн засаг дарга, түүний харъяа байгууллагууд МСҮТ-тэй хамтран ажиллаж зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд үндэслэж элсэлтийг авч төгсөгчдийг бодит ажлын байраар хангаж хамтран ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.



**“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ТӨРӨӨС
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.**



2.5.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын гамшгийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийг сэргээх, зах зээлийн идэвхжилийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх дунд хугацааны 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Энэхүү цогц төлөвлөгөөнд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг иргэнд **50.0** сая хүртэл, НӨАТ төлөгч аж ахуйн нэгжид **500** сая хүртэл төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатайгаар олгож эхлээд байна. Архангай аймагт тус 447 иргэн, ААНБ-д **23,442.9** сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Хүснэгт 17: Ажлын байр дэмжих зээл авсан байдал /сая.төг, хүн/

№	Төрөл	Тоо	Дүн	Үлдэгдэл
1	Аж ахуйн нэгж	82	10,272.6	
2	Иргэн	365	13,170.2	
	НИЙТ	447	23,442.8	21,201.9

Архангай аймаг дахь Монгол банкны салбар зөвлөлөөс тус зээлийн эргэн төлөлт болоод ажлын байр хадгалсан байдалд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ажлын байрыг хэрхэн хадгалж байгааг нууцын зэрэглэлтэй гэсэн тайлбарыг ирүүлсэн тул анхан шатны баримтаар шалгаагүй болно.



2.5.2. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах зорилгоор ЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Архангай аймагт 400 ААНБ-д 2020 онд **1,736.7** сая төгрөг, 2021 онд **341.8** сая төгрөгийн нийт **2,078.5** сая төгрөгийн НДШ-ийн хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлж, ажилгүйдлийн даатгалын сангаас **41** ААНБ-д **76.8** сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.



2.5.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй байна.

ХЭДС-ийн "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд малжуулах төсөлд **21** өрхөд **93.0** сая төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт **40** иргэнд **150.0** сая төгрөг, ажил олгогчийн урамшуулалд **3** ААН-д **40.3** сая төгрөг, аж ахуй эрхлэлтийн сургалтад **100** иргэнд **3.0** сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол улсын засгийн газрын шийдвэрээр зээлийн эргэн төлөлтийг хойшлуулснаас шалтгаалан цар тахлын үед олгогдсон зээлийн эргэн төлөх хугацааг **6** сараар хойшлуулсан бөгөөд 2022 оноос зарим төсөл хөтөлбөрийн эргэн төлөлт хийгдэж байна. Харин санхүүгийн дэмжлэг авсан иргэд бодит ажлын байрыг бий болгож, гэрээнд заасан НДШ-г төлөөгүй байна.



2.5.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик мэдээ бодитой бус байна.

2021 оны 4-р улирлын байдлаар хөдөлмөрийн насны хүн амын **68.6** хувь нь ажиллах хүч, **31.4** хувь нь ажиллах хүчнээс гадуур хүн ам байна. 2021 оны 4-р улиралд ажиллах хүч **42584** болж өмнөх оны мөн үеэс **7320** буюу **14.7** хувиар буурсан бол 2020 оноос **668** буюу **1.6** өссөн байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам **19464** болж өмнөх оны мөн үеийнхээс **3387** буюу **24.9** хувиар, 2020 оноос **1102** буюу **6.0** хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 18: Цар тахлын үеийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээ /хүн/

Үзүүлэлт	2019- IV	2020- IV	2021- IV	Өсөлт/Бууралт /өмнөх оны мөн үеэс/	
				Тоо	Хувь
Хөдөлмөрийн насны хүн ам	65481	60278	62048	-3433	(5.24)
Үүнээс: Ажиллах хүч	49904	41916	42584	-7320	(14.67)
Ажиллагчид	47532	40545	41252	-6280	(13.21)
Ажилгүй хүн	2372	1371	1179	-1193	(50.30)
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	15577	18362	19464	3887	24.95

Эх сурвалж: 1212.mn

2021 оны 4-р улирлын байдлаар ажиллагчид **41252** болж өмнөх оны мөн үеэс **6280** буюу **13.2** хувиар буурсан бол 2020 оноос **707** буюу **1.7** хувиар өссөн байна.



Харин ажилгүй иргэд 1179 болж өмнөх оны мөн үеэс 1193 буюу 50.3 хувиар, 2020 оноос 192 буюу 14 хувиар буурсан байна.

2019 онд аймгийн ажилгүйдлийн түвшин 5.4 хувь байсан бол 2020 онд 3.3 хувь болж 2.1 хувиар буурсан байна.

Энэ нь ажиллах хүчин буурч түүнээс шалтгаалан ажиллагчид буурсантай шууд холбоотой мөн, 2020 онд ковид-19 цар тахал гарсантай холбоотой байна.

Ажиллагчид буурснаар ажилгүй хүний тоо нэмэгдэх байтал ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо нэмэгдэж байгаа нь цар тахлын үед ажил хайх итгэл алдарч ХХҮГ-т ажилгүй иргэнээр бүртгүүлэх явдал багассантай холбож болох юм. Тэгэхээр ковид-19 цар тахлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн статистик тоо мэдээ үнэн бодитоор гараагүй байна гэж үзэхээр байна.

--oOo--

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН БАГАТАЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

- 1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой бүрэн уялдаагүй байна.
- 1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж чадаагүй байна.
- 1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар дундын төрийн бодлогын уялдаа холбоо бүрэн хангагдаж чадахгүй байна.

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГ БАГАТАЙ БАЙНА.

- 2.1. Хөдөлмөр эрхлэлтийн ниитлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөө багатай байна.
- 2.2. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн хангалтгүй байна.
- 2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй ч хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна.
- 2.4. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөө муу байна.
- 2.5. “Ковид-19” цар тахлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮН МУУТАЙ, ОРОН НУТАГТ АЖЛЫН БАЙР БОДИТООР НЭМЭГДЭЭГҮЙ БАЙНА.

Аудитаар **1,943.5** сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрч **1,569.5** сая төгрөгөнд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад чиглэсэн 16 албан шаардлага, арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэхэд **372.9** сая төгрөгийн **8** заалт бүхий зөвлөмжийг Засаг дарга, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, ХХҮГ, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн холбогдох байгууллагуудад дараах зөвлөмжийг хүргүүлээ.

Аймгийн засаг дарга М.Батжаргал, ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн дарга И.Амартүвшин нарт:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг харилцан уялдуулж, хамтран ажиллах

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Ч.Батнайрамдал, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Т.Аззаяа нарт:

1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн мэргэжилтэй ажилтныг ажлын байраар хангах, ажил олгогчийг дэмжих арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан уялдаатай хамтран ажиллах
3. ХЭДС-аас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлт, зээлийн эргэн төлөлт, ажилд зуучлагдсан иргэдийн ажлын байраар хангагдсан байдалд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд:

1. Төгсөгчдийг ажлын байраар хангахад Аймгийн засаг дарга, түүний харьяа байгууллагуудтай хамтран ажиллаж үр дүнг тооцож ажиллах
2. Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг нутгийн бодлого, хөтөлбөр зорилгод нийцүүлж, ажлын байрны судалгаанд үндэслэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, төгсөгчдийг ажлын байраар хангахад анхаарч үр дүнг тооцож ажиллах